

> Байгууллагын хөгжлийг дагаад бусад төрлийн миний төсөөлөлд тусгагдаагүй давуу талууд бий болохыг үгүйсгэх аргагүй юм.

ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
811 дүгээр дамжааны сонсогч,
дэд хурандаа Д.Пүрэвбаасан

ХИЛ ХАМГААЛАХ АЛБАНД АЖИГЛАГДАЖ БУЙ ЁС ЗҮЙН ЗАРИМ ЗӨРЧИЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

*“Амьдралд хүмүүс боловсролоороо бус
хүмүүжлээрээ ялгардаг ”*

1. Ёс зүйн талаар товчхон. Ёс зүй нь Ethika, ethes гэсэн грекийн зан заншил, зан суртахуун гэсэн үгнээс гаралтай. Судалгааны энэхүү тусгай салбарыг агуу их Аристотель анх этик гэдэг үгээр тэмдэглэжээ. Этика буюу ёс зүй нь тухайн орчинд хүмүүст тавих ёс суртахуун, зан суртахууны шаардлагыг илэрхийлсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл, ёс зүй гэж сайн, муу шударга, шударга бус зөв буруугийн тухай төсөөлөлд үндэслэгдсэн зан төлөвийн журмыг хэлнэ. Ёс суртахуун, зан суртахуун, ёс зүй гэсэн ойлголтууд хоорондоо нягт холбоотой, ижил утгыг илэрхийлэн давхцах шинжтэй ч байдаг.

Хүн байхын үндсийн үндэс нь ёс суртахуун бөгөөд ёс суртахууны илрэл нь ёс зүй гэж ойлгож болох юм. Аливаа мэргэжил ёс зүйн өвөрмөц шаардлагыг өөртөө бий болгодог. Өөрөөр хэлбэл мэргэжил бүхэн өөрийн ёс зүйтэй байна. Мэргэжлийн ёс зүй бол хүн ёсны үүднээс заавал сахин мөрдөх шаардлагатай бараг хууль ёсны гэж хэлж болох бичигдээгүй дүрэм журмын нийлбэр юм.

Хил хамгаалах байгууллагын офицерийн ёс зүй нь албаны бэлэн байдал, алба хаах нөхцөл, бичил бүлгийн болон мэргэжлийн онцлогоос урган гардаг. Монгол Улсын хилийн халдашгүй байдлыг хангах, төрийг төлөөлж орон нутгийн иргэд, хөрш зэргэлдээ улсын хилчидтэй харьддаг, төрийн хуулийг хэрэгжүүлж, хилийн болон хил орчмын дэглэм зөрчигчдөд зохих шийтгэл хүлээлгэдэг, хуулийн биелэлтийг хянадаг зэрэг мэргэжлийн онцлог байдлууд нь хилчин офицерийн ёс зүйн өвөрмөц нөхцөл юм.

Мэргэжлийн ёс суртахууны илрэл буюу хилчин офицерийн мэргэжлийн ёс зүй нь “Хил хамгаалах байгууллагын ёс зүйн дүрэм”-ээр мөрдөгдөн, хэрэгждэг.

Менежментийн онолоор байгууллагын үр ашигтай үйл ажиллагаа, хөгжлийн 90 хувь нь удирдлагын шийдвэрээс хамаардаг, удирдлагын шийдвэрт удирдагчийн суурь хүмүүжил, ёс суртахуун, ёс зүй, үзэл баримтлал үнэт зүйл шууд нөлөөлдөг гэж үздэг. Тэгвэл Хил хамгаалах байгууллагын удирдлагын залгамж халаа болсон, ирээдүйн удирдагч нар болох залуу офицерууд маань хил хамгаалах анхан шатны нэгжид үүргээ биелүүлэх явцдаа “ёс зүйн дүрэм”-ээ хэрхэн хэрэгжүүлж, тухайн нөхцөлд хэрхэн чадварлагаар үүргээ гүйцэтгэж байгаа бол...

2. Хугацаат цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын хамгаалалт, өнөөгийн байдал, дүгнэлт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ. “Монгол улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг

хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх” гэсэн Хууль зүйн яамны эрхэм зорилго, Монгол улсын үндсэн хуульд заасан торийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, шударга ёс, тэгш байдлыг хангах үүргийн хүрээнд Хил хамгаалах Ерөнхий газрын харьяа хилийн 0132, 0306, 0130, 0243, 0151, 0101 дүгээр ангиуд, тэдгээрийн нийт 25 заставт 2013 оны 9 дүгээр сарын 23-наас 10 дугаар сарын 25-ны хооронд хөндлөнгийн судалгааг явуулжээ. Судалгаагаар цэргийн алба хааж байгаа ХЦАХ-дын 65% нь 18-20 насны залуучууд байгаа ба боловсролын хувьд дунд боловсролтой 70%, нийгмийн байдлын хувьд хагас өнчин, нэн ядуу хүмүүс тодорхой хувийг эзэлж, хорих болон тэнсэн харгалзах ялаар шийтгэгдсэн залуус улсын хил дээр үүрэг гүйцэтгэж байгаа нь анхаарал татсан байна.

ХЦАХ-дын алба хаах явцад хэл амаар доромжлох, зодож цохих, мөнгө, эд зүйл нэхэх нэх мэт дарамтын аль нэг хэлбэрээс судалгаанд оролцогчдын 80% нь дарамтгүй, 12% нь зарим тохиолдолд, 8% нь дарамт байдаг гэж хариулсан нь алив хэлбэрийн дарамт бүрэн арилж чадаагүй байгааг харуулжээ. Сэтгэл санааны хувьд хүнд байдалд байгаа цэргийн албан хаагч байгаа эсэх талаархи санал асуулгад 95% нь “тийм юм байхгүй” гэж, алба хаахад бэрхшээлтэй талууд байгаа эсэх талаар асуулгад 60% нь “байхгүй” гэж, цэргийн албанд ирсэндээ харамсах явдал байдаг уу гэсэн асуултанд 88% нь “үгүй” гэж хариулжээ. Энэ судалгааны үр дүнгээр:

- Гарч байгаа хэрэг, зөрчил хилийн застав, харуулд голчлон үйлдэгдэж байгаа нь анхан шатны нэгжийн удирдах албан тушаалтнууд аж ахуйн ажилд түлхүү анхаарч, сургалт бэлтгэлийг орхигдуулдаг, өгсөн үүрэг тушаал, зааврыг заалт бүрээр бие бүрэлдэхүүнд судлуулан хэрэгжүүлдэггүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цэргийн сахилгыг бэхжүүлэхэд чиглэгдэн гарсан удирдлагын баримт бичгийг бүрэн судлуулж, мөрдүүлдэггүй.

- Хилийн зарим отряд, заставууд цэргийн албаны өдөр тутмын үйл ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулдаггүй, хяналт шалгалт сул, ялангуяа алслагдсан хэсэгт үүрэг гүйцэтгэж буй бүлгүүдийн ахуй хангалт, удирдлага зохион байгуулалт хангалтгүй байдал нөлөөлдөг байна.

Хил хамгаалах байгууллагаас ХЦАХ-дын хуулиар баталгаажсан эрхийг хамгаалах, хангах талаар дараах арга хэмжээг авч байна.

- ХХЕГ-ын даргын 2011 оны а/22 тоот тушаалаар байгуулагдсан “Тэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цэргийн сахилгыг бэхжүүлэх зөвлөл” хилийн отряд, ангиудад ажиллаж, ажлаа жил, сараар төлөвлөн сахилгын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, цэргийн сахилгыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулснаар хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2012 онд 2011 онтой харьцуулахад хэрэг зөрчлийн тоо 29,03 хувь, холбогдсон хүний тоо 47,05 хувиар тус тус буурсан байна

- ХЦАХ-дыг шударга ёсыг эрхэмлэх, албаараа бахархах, эх оронч, хилч үзэл төлөвшүүлэх, санал сэтгэлийг тогтвортой байлгах үүднээс социологийн судалгаа явуулах, сэтгэл зүйн бэлтгэл олгох сургалт дадлагыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж, халамжлан сургагчийг томилох, санал хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

- Хил хамгаалах байгууллага сүүлийн үед хилийн отряд, ангиудын бүтэц, орон тоонд нэлээд өөрчлөлт хийж, ангийн төвд сэтгэл зүй, соёл сурталчилгааны алба, дотоод хяналт, аюулгүй байдлын албадуудыг шинээр байгуулснаас гадна

сэтгэл зүйч офицер, өргөдөл гомдол хариуцсан офицер зэрэг албан тушаалтны орон тоог шинээр нэмж ажиллуулж байгаа нь ЦАХ-дыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цэргийн сахилгыг бэхжүүлэх, эх оронч хилч үзэл төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Ингэснээр алба хаагчдын зүгээс ХЦАХ-дын эрх ямар нэг байдлаар ноцтой зөрчилгүйгээр хангагдаж байна гэж үзсэн.

Гэвч “Мэдээлэл соёл сурталчилгааны ажлыг зөвхөн соёл, урлаг, соёлын арга хэмжээгээр хязгаарлаж, хууль дүрмийг бие бүрэлдэхүүнд хүргэх, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажлыг орхигдуулснаас хууль дүрмийг чандлан биелүүлэх ёс зүйн болон сэтгэлгээний төлөвшил бие бүрэлдэхүүнд бүрэн төлөвшиж чадаагүй байна” гэж дүгнэжээ. Тэгэхээр залуу офицеруудын маань ёс зүйн болон сэтгэлгээний төлөвшил бүрэн төлөвшиж чадаагүй болж байна.

3. Хил хамгаалах албанд ажиглагдаж буй зарим ёс зүйн зөрчил

Манай улс 1990 оноос хойш зах зээлийн нийгэмд шилжсэнээр хүн ардын амьжиргааны түвшин эрс ялгарч, нийгмийн хувьд хэн мөнгөтэй, танилтай нь албан тушаал ахиж, энэ ч талаасаа албан тушаалын болон авилгын хэргүүд гарах болсон.

Харин хил хамгаалах байгууллагын хувьд албаны онцлогоос хамаарч энэ төрлийн зөрчил нь харьцангуй бага, харин цэргийн алба хааж байгаа залуусын боловсрол, нийгмийн гарлаас шалтгаалж ёс зүйн зөрчил гардаг.

Мөн энэ байдалд үндсэн бүрэлдэхүүний харьдаа ч зарим талаараа нөлөөлсөн, анхан шатны нэгжид голчлон илэрдэг нь дээрх судалгаагаар дүгнэгдсэн ба нийгмийн хөгжлөө дагаад доорх ёс зүйн зөрчлүүд гарч байгаа нь ажиглагдаж байна.

1. Албанд татагдсан ХЦАХ-дын сэтгэл санаа, гарал үүсэл, нийгмийн байдал зэргийг тодорхой судалсан боловч нэг дороос ирсэн залуусыг нэг заставт хамтад нь хуваарилсан, тэдэнтэй тогтмол ажиллаж, сэтгэл санааны өөрчлөлтөд хяналт тавиагүй, алба хаах нөхцөлд нь анхаараагүйгээс нийгмийг цочроосон гэмт хэрэг ХЦАХ-даас гарч байсан. /хилийн 0129 дүгээр ангид болсон гэмт хэрэг 2009 он/

2. Сургууль төгсөөд шинээр очиж байгаа хилчин офицеруудад цэргийн сахилга бат, офицерийн удирдах захирах авьяас, офицерийн нэр, төр, цэргийн хамт олны дундах зан суртахууны харилцаа, очиж ажиллах анхан шатны нэгжийн талаар сайтар ойлгуулж хэлэх нь чухал байдаг. Учир нь дөнгөж төгсөөд очиж байгаа офицер, түүний гэр бүл төлөвшөөгүй байдал, харин олон жил ажилласан орон нутгийн ахлагч, тэдний гэр бүл, нийгмийн гарал, өссөн орчин, суурь хүмүүжил зэргээс шалтгаалж, тэдгээрийн хооронд бие биенийгээ үл ойлголцох, үл хүндлэх харилцааны зөрчил гарч, энэ нь албанд сөргөөр нөлөөлөх асуудал гарч байна.

3. Албан хаагчдыг ажилд авахдаа сайтар судлаагүйгээс тэднээс удирдах дарга нартайгаа зөрчилдөх, цэргийн дүрэм, ёс зүйн дүрмүүдийг сайтар ойлгоогүйгээс архи уух, ард иргэдтэй буруу харьцаж, хилчдийн нэр төрийг унагаах зэрэг ёс зүйн зөрчил гарч байна. Сүүлийн жилүүдэд энэ байдалд захиргааны арга хэмжээг тогтмол авснаар багасаж байгаа боловч байсаар байна.

4. Сүүлийн жилүүдэд залуу офицеруудаас хурдхан том дарга болох хүсэл их болж, үүний тулд буруу зөв аргууд хэрэглэх нь ихсэж байна.

5. Офицер, ахлагч нараас ХЦАХ-тай зүй бус харьцах, нэр төрийг гутаан доромжлох, ялгавартай хандах зэргээр сэтгэл санааны дарамт үзүүлэх

4. Эдгээр ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх арга зам

Дээрх ёс зүйн зөрчлүүдээс урьдчилан сэргийлж, шийдвэрлэхийн тулд:

1. Хилчин **офицер бүр ёс суртахууны зарчим, ойлголтуудыг өдөр бүр амьдралд мөрдөж хэвшүүлэх** хэрэгтэй.

Ёс суртахууны зарчим бол байгаль, нийгэм, ахуйтайгаа харилцах харилцаанаас урган гарч байгаа ёс суртахууны үндсэн үзлийг хэлнэ. Энэ талаар “Хил хамгаалах байгууллагын ёс зүйн дүрэм”-ийн 3.1-д: Хил хамгаалах байгууллагын албан хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмыг баримтална:

шударга ёсны

хууль дээдлэх

тэгш байдал

хариуцлага хүлээх

олон нийтэд үйлчлэх гэж эрх зүйн баримт бичгээр баталгаажуулсан.

Дээрх зарчмуудыг бүх шатанд ойлгон хэрэгжүүлснээр ёс зүйн зөрчилгүй хамт олон болох боломжтой юм. Энэ талаар сонсогчдод онолын мэдлэг хичээлээр өгч байгаа нь сайшаалтай боловч, яг ажил дээр гараад орчинд нь сургах, “Ёс зүйн дүрэм”-ийг агуулгаар нь тайлбарлан хүргэх, мөрдүүлэх, төлөвшүүлэх ажлыг хариуцсан албан тушаалтан өөрсдийн үүргээр хүлээсэн ажлаа чанаржуулах, сэтгэлээсээ хийх шаардлагатай байна.

2. Хилчин офицер бүр ажил хэрэгч ёс зүй буюу оюунлаг чанар/үнэнч шударга байх, үүрэг хариуцлагаа ухамсарлах, хувийн ба байгууллагын нэр төрийг эрхэмлэх, өрсөлдөгчөө хүндэлдэг байх зэрэг/-ыг удирдлага болгон дээрх зарчмуудыг мөрдүүлснээр албаны үйл ажиллагаа хэвийн явагдаж, алба хаагчдын болон байгууллагын нэр төр өндөрт өргөгдөх болно.

3. ХСИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад тухайн агентлагуудын “Ёс зүйн дүрэм”-ээр төгсөх курст нь тусгайлан хичээл орж, шалгалт авдаг, цаашлаад ажилд томилогдоод хэрхэн албанд мөрдөж, хэрэгжүүлж, тухайн албан тушаалтан мэргэжлийн ёс зүйн хувьд хэрхэн төлөвшиж байгаад холбогдох албан тушаалтнууд хяналт тавьдаг, энэ үзүүлэлт нь цаашид албан тушаал ахих үндсэн үзүүлэлтийн нэг болох ёстой гэж үзэж байна.

4. Дээрх залуу офицеруудаас гарч буй ёс зүйн зөрчил, алдаануудыг хариуцсан албан тушаалтан, ахлах офицеруудаас ёс зүйн дүрэм, ёс суртахууны зарчимуудаар ухуулан сэнхрүүлж, ажил албанд нь заавал мөрдүүлэн, засаж, залруулан, манлайлаж шийдвэрлэх нь дээрх зөрчлүүд ёс зүйн тулгамдсан асуудал болохоос урьдчилан сэргийлэх арга зам, гарц болж байгаа юм.

5. Дарга болохын тулд анхан шатнаасаа зөв дэс дарааллаар тодорхой хугацаанд сайн ажиллаж, суралцах, үүнийгээ ажлаараа батлах ёстойг хүний нөөцөөс сайтар ойлгуулж байх нь чухал байна.

6. Офицер, ахлагч нар ХЦАХ-дтай харилцахдаа албан харилцааны хэлбэр буюу дүрмийн дагуу харьцаж сурах, түүнийгээ хэрэгжүүлэх, аливаа харилцаанд хувийн сэтгэл хөдлөл, сөрөг сэтгэл хөдлөл, уур бухимдал зэргийг гаргахгүй байх, захирагсдыг үлгэр жишээч байдлаар зөв удирдах зохицуулах аргад суралцах шаардлагатай байна.

7. ХЦАХ-дад хүүхэд наснаас нь шударга ёсыг эрхэмлэх, цэргийн албаараа бахархах, эх оронч, хилч үзэл төлөвшүүлэхийн тулд “Цэргийн алба хаах нь иргэний

журамт үүрэг мөн" болох нь талаар ерөнхий боловсролын дунд сургуулийн 11,12 дугаар ангиудад тусгай хичээл зааж, тэднийг багаас нь цэргийн албаны хүнд бэрхийг даван туулах сэтгэл зүйн бэлтгэлтэй болгох зэрэг болно.

8. "Монгол Улсын Төрийн албаны зөвлөл"-өөс "Төрийн албаны шинэтгэл, сорилт. боломж" Үндэсний анхдугаар чуулганаас эх орондоо ардчилсан, сайн засаглалыг төлөвшүүлэн бэхжүүлж, хөгжлийн таатай нөхцөлийг бүрдүүлэн, төр, иргэний итгэлцэлд тулгуурлан чанартай үйлчилгээг ард түмэндээ хүргэхийн төлөө төрийн нийт албан хаагчдад Монгол Улсын Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг гаргаж тогтоосон. Үүнийг хэрэгжүүлэх үндэс нь "ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилт, ёс зүйн төлөвшил юм.

Эцэст нь ухамсарт хүн бүр "хүн шиг хүн" байхыг л чухалчилж ёс зүйтэй амьдран, аз жаргалтай байхыг хүсэн, "Офицер бол оюун ухаан, бие бялдрын төгс бие хүн ба харин зөв хүмүүжил, ёс зүй нь жинхэнэ бие хүний үндэс юм" хэмээн үзэж байна.